



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 08 дугаар сарын 12 өдөр Дугаар 43

Хэрлэн сум

ХХХХIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 43 дугаар хурал Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхтгосон хэлбэрээр 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат даргалж, холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1.Тусгаарлалтад байгаа "ДБЭХС" ТӨХК-ийн хүчин чадлыг 50 МВТ-аар нэмэгдүүлж, өргөтгөх төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын "ТВЕА" ХХК-ийн 31 иргэнийг гэрийн ажиглалтад шилжүүлэх эсэх талаар,

Мэргэжлийн хяналтын газар

2."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн ХХI талбайн төв зам хүртэлх 58,5 км замыг тавихад шаардагдах цементийн асуудлыг дахин хэлэлцэж, шийдвэрлүүлэх,

Мэргэжлийн хяналтын газар

3.Харшлын талаар мэдээлэл хийх,

Эрүүл мэндийн газар

4.Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2020 оны 5 дугаар сард хилийн Баянхошуу боомт, Халхгол сум, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн газрын тосны 21, 19 дүгээр талбайд ажилласан хугацааны шатахуун, томилолтын зардлыг шийдвэрлэж, холбогдох зардлаас гаргах эсэх талаар,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-Өлзий

5.Онцгой комиссын дарга болон гишүүдийн саналаар нэмж хэлэлцүүлэх асуудлын талаар,

Онцгой комиссын гишүүд

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. БНХАУ-ын 31 иргэний тусгаарлалтын 21 хоногийн хугацаа дууссантай холбогдуулан гэрийн ажиглалтад байлгах барилга байгууламжийн ажил дуусаагүй байгаа тул холбогдох мэргэжлийн байгууллагуудын саналыг үндэслэн дээрхи иргэдийг байрлуулах түр барилгыг ашиглалтад хүлээн авах хүртэл хугацаанд гэрийн ажиглалтыг Чойбалсан буудалд үргэлжлүүлэх, доторх дэглэмийг буулгаж, гадна талын хамгаалалт, хяналтыг Онцгой байдлын газар болон Цагдаагийн газар үргэлжлүүлэн зохион байгуулахыг аймгийн Онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэв.

2. Баптист сүмийн үйл ажиллагааг хэвийн явуулж өгөх талаар гаргасан хүсэлтийг хэлэлцэн тус сүмийн үйл ажиллагааг нээхгүй байхаар аймгийн Онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэв.

Нэг. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын орлогч,
УСТ-ийн дарга Онцгой комиссын нарийн бичгийн дарга,
дэд хурандаа Д.Баттулга,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

1.1. Тусгаарлалтад байгаа "ДБЭХС" ТӨХК-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж, өргөтгөх БНХАУ-ын 31 иргэнийг гэрийн ажиглалтыг Чойбалсан буудалд үргэлжлүүлж, доторх дэглэмийг бууруулж, гадна талын хяналт, шалгалтыг Онцгой байдлын газар, Цагдаагийн газар хамтран хэрэгжүүлж, хамгаалалтыг үргэлжлүүлэн авахыг,

Хоёр. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

2.1. Гар утасны апплейкшний төлбөрийн зардлыг шийдвэрлүүлэх,
2.2. Гэрийн ажиглалтад байх хугацаанд гарсан зардлыг "ТВЕА" ХХК-иар төлүүлэх талаар албан бичиг хүргүүлэхийг,

Гурав. Эрүүл мэндийн газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа нарт

3.1. "Их Монгол барилга" ХХК-ийн цемент татах 4 жолоочид халдвар хамгаалалтын хувцас өмсөж тайлах талаар сургалт, заавар, зөвлөмж өгөхийг,

3.2. Дээрх компанийг эмч, эмнэлгийн ажилтантай болгож, сургаж дадлагажуулах чиглэлээр Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг,

3.3. Баптист сүмийн үйл ажиллагааг нээхгүй байх талаар Мэргэжлийн хяналтын газраас албан бичиг хүргүүлэхийг,

Дөрөв. Эрүүл мэндийн газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д

4.1.Харшил юунаас шалтгаалж байгаа, хэдэн төрлийн харшил байгаа талаар дэлгэрэнгүй судалгаа гаргаж танилцуулахыг,

Тав. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч,
УСТ-ийн дарга, Онцгой комиссын нарийн бичгийн дарга,
дэд хурандаа Д.Баттулга-д

5.1. Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан II ажлын хэсэг 2020 оны 05 дугаар сард хилийн Баянхошуу боомт, Халхгол сум, Петровичайна Дачин Тамсаг ХХК-ийн газрын тосны 21, 19 дүгээр талбайд ажилласан хугацаанд гарсан шатахуун, томилолтын зардлыг холбогдох зардлаас гаргахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН
ОРЛОГЧ ДАРГА Ч.ГАНБАТ

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА